

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

## ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

“Кибернетик ББСБ” ХХК-д гадаад валютын  
арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Кибернетик ББСБ” ХХК-д гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл нэмж олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тус тус тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэн, нотлох баримтыг 2008 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Кибернетик ББСБ” ХХК /Б.Бадамгарав/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ